



Үхлийг ойлгохын ашиг тус:

Үхэл бол сайн мэдээний үндсэн чухал хэсэг

Үхэл юу болох тал дээр Бичвэрүүдийн үгс, хүний уламжлал хоёр зөрдөгийг бид өмнөх хэдэн нийтлэлээс харсан. Эртний уламжлалын дагуу, нас барсан хүний сэтгэл үхэшгүй мөнх бөгөөд нэг бол тэнгэрт, нэг бол тамд хальж одно. Харин Библийн дагуу хүн нас барахад амин сүнс нь Бүтээгч Эзэн рүү буцна, бие махбод нь хөрс шороонд буцна, харин сэтгэл (буюу юм мэдэх, мэдрэх чадвар) нь тэр өдөртөө мөхөөд үгүй болно. Нас барсан бүх хүн үхлээс амилах өдөр хүртэл булшин дотроо нойрсох мэтээр ухаан мэдрэлгүй хэвтдэг гэсэн үг. Үхлийг ийм энгийнээр тайлбарлаж өгсөн Их Эзэний үгэнд итгэх нь ямар ашиг тустай, яагаад амин чухал болохыг энэ нийтлэлд цаашлан судална.

1. Үнэн биднийг айдсаас чөлөөлнө

Юуны түрүүнд хэлэхэд, үнэнийг мэдэх нь биднийг хэзээд чөлөөлдөг (Иохан 8:32). Үхлийн тухай үнэн мөн адил.

Хүн болгон үхлээс айдаг. Нас барахаар хаашаа явж, ямар ямар аймшигт зүйлтэй тулгарахаас айна. Гэтэл үхлийг нойрсон амрахтай төстэй гэж мэдсэн хүн үхлийн цаана янз бүрийн аймшиг хүлээхийн талаар санаа зовохоо болино.






Үхлээр оршихоо болино гэж бодохоор мэдээж бас л тодорхой хэмжээний аймшигтай. Тиймээс үхлийн үнэнийг заавал үхлээс амилахын үнэнтэй хослон ойлгох нь зөв. Бид үхсэн ч эргээд амилах нь баталгаатай гэж мэдэж авахлаар үгүй болохын аймшиг ч намдана.

Хайртай талийгаач хүмүүс үхлээр энэ дэлхийн хэцүү

амьдралаас салж, хэсэг хугацаа амарч байгаа бөгөөд дараа нь дахин уулзах өдөр ирнэ гэдгийг мэдсэн нь үлдэгсдэд тайвшрал өгнө.



Нөгөө талаар нас барсан муу хүний сүнс ирж зовооно гэсэн түгээмэл айдсаас ч үхлийн тухай үнэн биднийг чөлөөлнө. Зовоож чаддаг өөр төрлийн сүнс байдаг ч гэсэн, таньдаг байсан муу хүн тэгэж зовоож чадахгүй гэж мэдэх нь зарим хүнд тустай биз ээ.

Үхэл ба амиллын үнэнийг мэдсэн итгэгч өөрийгөө ч, хайртай бүх хүмүүсээ ч Их Эзэний гарт даатган өгч, үхлийн айдсаас чөлөөлөгдөнө.




2. Үнэн биднийг хуурагдахаас хамгаална

Үнэнийг мэдэх нь биднийг чөлөөлөөд зогсохгүй, хуурагдан мэхлүүлэхээс хамгаална (2 Тесалоник 2:10-11). Гэвч үнэнийг нандигнан эрхэмлээгүйгээс болж итгэдэггүй хүмүүсийн дунд бүү хэл, Христийн сүм чуулганд хүртэл дэндүү олон хуурмаг ойлголт ба төөрөгдөл бий.

“Үнэнийг зүй бусаар нуун дарагч хүмүүсийн... эсрэг Бурханы уур хилэн тэнгэрээс” илчлэгдэх болно. Ертөнцийн Эзэнийг олон хүн мэдсэн ч Түүнийг ертөнцийг бүтээсэн агуу их Эзэнд зохих байдлаар алдаршуулдаггүй. Жишээлбэл, Түүнд итгэдэг гэж баримталсан ч хэлсэн Үгийг нь тоомсорлодоггүй олон хүн байдаг. Ийм худал хуурмаг байхын үр дүнд “бодол санаа нь хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ. Өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон” (Ром 1:18-22).

Ертөнцийн Эзэний хэлсэн үгийг тоохгүйн жишээд “сэтгэлийн үхэшгүй”-н тухай янз бүрийн шашны сургаалыг дурдаж болно.

Ертөнцийн Эзэн “нүгэл үйлдэгч хүн [еврей: сэтгэл] үхэх болно” гэж тов тодорхой хэлсэн (Екекиел 18:20). Тэгсэн ч гэсэн олон христитгэлт хүн “нүгэл үйлдэгч хүний бие үхсэн ч, сэтгэл нь амьдаараа мөнхийн зовлонт тамд орно” гэдэгт итгэдэг.






Буддын шашны сүсэгтэн болохоор “нүгэл үйлдэгч хүний сэтгэл хойд насандаа жоомны биеэр дахин төрнө” гэх зэрэг үзэлтэй байдаг.

Бөө шашны дагуу үхэгсэд “өөд болж”, тэнгэрийн доод хэсэгт байдаг “харанхуйн орон”-д очиж “бурхан болдог”.¹

Тэр бүх үзэл бодол мэдээж бүгд зэрэг үнэн байх боломжгүй. Нэг нь л үнэн бөгөөд бусад нь худлаа. Алдартай герман философич Кант хэлэхдээ, “Үнэн бол хүнээр тодорхойлогдоно.” Итгэгч хүн Кант гуайтай санаа нийлж чадахгүй. “Үнэн бол Бүтээгч Эзэнээр тодорхойлогдоно” гэвэл зөв.



Үхлийн талаарх Ертөнцийн Эзэний үгийг үл тоож, зүрх сэтгэл нь харанхуйлсан хүн бол харанхуйн хүчинд мэхлүүлэх аюулд байдаг.

Үхэгсэд амьд хэвээрээ гэдгийг үнэмшсэн олон хүн тэднээс мэдээлэл авах боломжтой ч гэж үздэг. Маш олон хүн энэ замаар хууртагдаж явна. Тэд хайрт талийгаачтайгаа ярих, эсвэл олон зууны өмнө амьдарч агсан алдартай хүнээс юм асуухыг хүснэ. Олон хүн үнэхээр үхэгсэдтэй харьцаж үзсэн, бас яалт ч үгүй тохирсон хариу авсан гэж үнэмшилтэйгээр баримталдаг. Үхэгсэд өөр байдлаар амьд хэвээрээ гэсний баталгаа мэтээр энэ танд санагдаж магад.

1 Астрал аялал нь сэтгэлийн дахин төрөхийг баталдаг гэж итгэдэг хүнд хэлэхэд, Ертөнцийн Эзэний Үгийн дагуу үхлээр “мөнгөн олс тасарч, алтан аяга хэмхэрч” бие махбод шороондоо буцаж, амин сүнс нь “үүнийг өгсөн Бурханд буцна”. Тэрнээс наана Бүтээгч Эзэнээ санаж эрэлхийл! (Номлогчийн үгс 12:6-7)



Гэтэл танд сонголт бий: Хүмүүсийн үгэнд итгэх үү?
Ертөнцийн Эзэний Үгэнд итгэх үү?

Их Эзэний талд буй хүн энэ зарчмыг өөрийнх
болгоно: “Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн!”
(Ром 3:4)

Ертөнцийн Эзэний үнэнээс зууралдах хүн “үхэгсэд
юу ч мэддэггүй” гэж бичүүлсэнд нь үнэмших болно
(Номлогч 9:5). Энэ шалтгаанаар Их Эзэн:

“Сүнс дуудагчид, үзмэрчид дээр бүү оч. Тэдэн рүү
хандаж бүү бузарт” хэмээн тушаасан (Левит 19:31,
СМО).

Бүтээгч Эзэний Өөртөө татаж хураасан хүний амин
сүнсийг хүн дуудна гэж угаасаа байхгүй (Иов 34:14-
15).





Гэтэл сүнс дуудсан хүнд бузар сүнс хариулж, нас барсан хүний дүрээр жүжиглэх зуун хувь боломжтой. Үхэгсдээс авсан үгс муу ёрын сүнсний худал үг болж таарна.²

3. Үхэл бол аврагдахын тулд итгэх сайн мэдээний үндсэн хэсэг

Үхлийн тухай үнэнийг мэдэх хамгийн чухал шалтгаан бол энэ: Үхэл бол бидний аврагдахын тулд хүлээн авах ёстой сайн мэдээний маш чухал ач холбогдолтой нэгэн хэсэг. Тухайлбал:



- 2 Иудагийн (1:14-г) иш татсан «1 Енох» хэмээх эртний еврей номын дагуу бузар сүнс бол эрт дээр үед үхсэн нэфийлүүдийн сүнс юм (АБ: Нефилим). Мөн Иудагийн (1:6-г) дурдсан “эрх мэдэл бүхий байр сууриа сахилгүй, харин ч орон байраа орхисон тэнгэрэлч” нар бол энэ дэлхийг харж хамгаалах үүрэгтэй ч, хүний охидуудтай ханилсан “Бурханы хөвгүүд”. Энэхүү нэгдлээс төрсөн нэфийлүүд жирийн хүн биш, харин аврага биетэй, ер бусын хүчтэй, ёрын муу чанартай байв (Эхлэл 6:4, бас Тооллого 13:33-г үзнэ үү). Эртний домгийн баатар буюу “хагас бурхан” гэж алдаршсан нэфийлүүд дэлхийн хаадууд байжээ. Жирийн хүн биш тэд нас барсан ч бузар сүнс болон амьд хүмүүсийн ертөнцөд тэнэдэг болсон. Тэд бол Есүсийн тааралддаг муу ёрын сүнс мөн бөгөөд өнөө хүртэл Сатанд үйлчлэн, энэ дэлхийд муугаар нөлөөлж байна. МЭ эхний 400 жилийн турш Христитгэлт Чуулганы бүх эцгүүд ийм ойлголттой байсан. Еврейгээр нэфийлүүдийн бузар сүнсийг “рефайим” гэж тодорхойлдог нь орчуулганд тэр болгон тодорхой гардаггүй. Ямартай ч, сэрж босох “үхэгсдийн сүнс” (Исаиа 14:9; СМО: “сүгүүд”) хүний сүнс биш, харин үхсэн нэфийлүүдийн буюу муу ёрын сүнснийх юм. Үүнчлэн сүнс дуудахаар хариу өгдөг үхэгсдийн сүнс бол хүнийх биш, харин үхсэн нэфийлүүдийн буюу муу ёрын сүнснийх мөн. “Чөлөөлөлтийн жилүүдийн ном” гэдэг бас нэгэн эртний еврей номын дагуу нэфилүүдийн сүнсний дийлэнх нь газар доор буй өөрийн гэсэн Үхэгсдийн оронд хоригдсон гэдэг. “Үхэгсдийн орон” бол “үзэгдэхгүй” буюу “хаана байдаг нь мэдэгдэхгүй” гэсэн утгатай билээ.



“Та нарт тунхагласан сайн мэдээгээ би та нарт мэдүүлье.

Та нар түүнийг хүлээн аваад түүндээ зогссон. Хэрэв миний тунхагласан үгийг та нар баримталж бас дэмий хоосон итгээгүй л бол, та нар түүгээр аврагдсан.

Учир нь би хүлээж авсан зүйлийнхээ хамгийн чухлыг та нарт дамжуулсан.

Бичвэрийн дагуу

Христ бидний нүглийн улмаас үхсэн бөгөөд оршуулагдан, Бичвэрийн дагуу гурав дахь өдөртөө амилуулагдсан...”
(1 Коринт 15:1-4)



Есүс Христийн үхэл “бичвэрийн дагуу” байсан.

“Бичвэр” гэдэг нь «Хуучин гэрээ»-г хэлдэг нь маргаангүй. Тэгвэл “Христ... үхсэн” гэдэгт ёсоор нь итгэхийн тулд үхэл юу болохыг «Хуучин гэрээ»-ний тайлбарласнаар ойлгоод итгэх ёстой.

Өмнөх хэд хэдэн нийтлэлд авч үзсэн «Хуучин гэрээ»-ний олон ишлэлийн дагуу Есүс үхэхдээ үнэхээр бүх талаараа амьгүй болсон. Тэрээр биеэрээ булшинд хэвтсэн, амин сүнс нь Ертөнцийн Эзэнд буцсан, сэтгэл нь “Үхэгсдийн орон”-д (өөрөөр хэлбэл, үл орших байдалд) орсон (Лук 23:46, Үйлс 2:27).



Энэ бүхний баталгаагаар “Христ оршуулагдсан” гэж бичсэн байна. Харин гурван хоногийн дараа Ертөнцийн Эзэн-Эцэг Есүст амин сүнсийг буцаан өгч, Түүнийг амилуулсан.

Жинхнээсээ л үхсэн нэгэн л дахин амилах боломжтой. Үхлийн амьгүйд оролгүйгээр үхэгсдийн дундаас амилна гэж байхгүй.

Христ үхлээс амилсан нь сайн мэдээний маш чухал хэсэг болох нь тодорхой. Христ үхээд амилсан хэмээх түүхийн бодит баримтад итгэсэн хүн бүр түрүүлж аврагдан, Түүний Биеийн гишүүн болж, Есүсийг буцаж ирэхэд үхэшгүй амьтай болж, ирээдүйн бүх үеүдийн турш Түүнтэй хамт амьдрах болно. Үүнийг “мөнхийн амьдрал” гэж нэрлэдэг.



Гэтэл үхэл гэж юу болохыг ойлгохгүй хүн үхлээс амилахын утга учрыг ч ойлгохгүй. Апостол элч нар Христийг үхлээс амилсан, итгэгч биднийг ч ирээдүйд амилах тухай байнга дурддаг байсан боловч орчин үеийн сургаал заагч нар ирээдүйн амиллын тухай бараг ярьдаггүй.

Итгэгч хүн хэрэв нас барангуутаа тэнгэрт явж, ер бусын жаргалд шууд орох бол дахин амилахын хэрэг юу байна?

Дахин хэлье, Бичвэрүүдийн дагуу үхэл ямар ч амьгүй байдлыг хэлнэ. Энэ үнэнийг бид хүлээж авахгүй бол Христ “үхэгсдийн дундаас амилсан” гэдгийг ч үнэний дагуу ойлгон, хүлээн авч чадахгүй.



Тийм байхад Христийн үхэл ба дахин амилалд Бичвэрүүдийн тайлбарласнаар итгэхгүй хүнийг “сайн мэдээнд итгэсэн” гэж тооцож болно гэж үү? “Есүс нас барсан, гэхдээ зөвхөн биеэрээ нас барсан” гэж баримтлах нь Паулын дурдаж байсан “дэмий хоосон итгэх”-ийн нэг хэлбэр биш гэж үү?³

Энэ бол үнэхээр бодууштай асуулт.

Үхэл чухам юу болохыг зөв ойлгох нь тийм чухал хэрэг шүү. Зөвхөн Их Эзэний үгэнд итгэсэн хүн бол жинхэнэ итгэгч мөн учраас тэр.



- 3 “Гэхдээ Есүс нас бараад Үхэгсдийн оронд бууж тэнд сургаал заасан биз дээ” гэж бодсон хүнд хандахад: Энэ талаарх ишлэлийг та сайн уншаарай. Үүнд: Христ “махбодод үхэж, сүнсэнд амилуулагдав. Тэрхүү сүнсээр Христ явж, шоронд байгаа сүнснүүдэд тунхаглажээ” (1 Петр 3:18-19). Юу гэвэл, Есүс Эзэн үхээд амилсан бөгөөд үүний дараа л тунхагаа хийв. Үхэгсэд юу ч мэдэхгүй, хаашаа ч явахгүй, юу ч ярихгүй. Сүнс бол амь өгдөг бөгөөд үхэгсдээс амилсан Их Эзэн энэ ажлыг хийсэн.
- Үүнээс гадна, чухам хэнд Христ тунхаг хийсэн нь сонирхолтой. Үүнд: “шоронд байгаа сүнснүүдэд”. Библид хүнийг “сэтгэл” гэж нэрлэдэг болохоос хэзээ ч “сүнс” гэдэггүй. Петрийн дараах үгнээс харахад эдгээр сүнс Ноагийн үед “дуулгаваргүй байсан”. Чухам эдгээрийг Иуда ч дурдан, “эрх мэдэл бүхий байр сууриа сахилгүй, харин ч орон байраа орхисон тэнгэрэлч” гэж тодорхойлсон (1:6). Энэ итгэлгүй тэнгэрэлч нарыг “Тэрээр агуу их өдрийн шүүлт хүртэл мөнхөд хүлээстэй нь харанхуйд хорьжээ.” (Мөн дээрх 2-р зүүлт тайлбарыг үзнэ үү.) Дахин амилсан Христ хүмүүсийн дунд зогсохгүй, ер бусын элч нарын дунд ч ажлаа хийдэг хэмээн Петр бидэнд энэ үгээрээ мэдүүлэхийг хүссэн.



Үхэх тавилантай сэтгэлийн тухай Библийн сургаалыг хүлээн авч чадахгүй олон христитгэлт хүн бий. Тэд Христийн үхэл ба дахин амилалд ёсоор нь итгэж, үнэн итгэгч мөн эсэхийг зөвхөн Их Эзэн л мэднэ. Та ч өөрөө өөрийгөө мэднэ.

Есүс Их Эзэн таны хийсэн бүх гэмийг авч хаях гэж үнэхээр амиа өргөсөн, өөрөөр хэлбэл гурван хоногийн турш амьгүй болж, оршихоо больсонд та итгэдэг үү?

Тэр үнэхээр үхэгсдийн дундаас дахин амь орсонд та итгэдэг үү?

“Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдана.” (Ром 10:9)

“Та нар итгэлд байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө судал...”
(2 Коринт 13:5)



“Хэрэв Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хоосон...”

Харин чухамдаа Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдын анхны үр жимс мөн.

Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ.

Адам дотор бүгд үхдэгчлэн

Христ дотор бүгд амьд болгогдоно.

Харин тус бүр өөрийн дараалалтай байна.



Христ бол анхны үр жимс юм.
Дараа нь **Христийн хүмүүс Түүнийг ирэхэд
амилуулагдана...**
(1 Коринт 15:17-24).

□

*Дараагийн нийтлэлд үхлийн үнэн ба амиллын
найдлагын тухай гэрчилдэг хамгийн эртний
Бичвэрийн гэрчлэлийг авч үзэх болно.*

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org